



ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 55

Дорноговь аймаг, Сайншанд сум

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, 25 дугаар зүйлийн 25.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/11 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн төлөө хамтдаа” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулан, хэрэгжилтийн тайланг бүтэн жилээр гарган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга Т.Энхтүвшинд үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Н.Хонгорзулд даалгасугай.

ДАРГА

С.ТҮМЭНБАЯР



0000142



**“ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД”
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Засгийн газраас сүүлийн 20 жилийн хугацаанд “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний дөрвөн хөтөлбөр (1997-2016), “Эхийн эндэгдлийг бууруулах стратеги” (2001-2004, 2005-2010), “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж стратеги” (2009-2013), “Эх, нярайн эрүүл мэнд стратеги” (2011-2015), “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх стратеги” (2014-2020), “Нярайн тандалт, шинжилгээний хөтөлбөр” (2014-2020) зэрэг 10 гаруй бодлогын баримт бичгийг хэрэгжүүлсэн.

Дээрх үндэсний хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэх Дорноговь аймгийн дэд хөтөлбөрүүд, стратегиудыг батлуулан үе шаттай хэрэгжүүлсний үр дүнд аймгийн хэмжээнд сүүлийн 8 жилийн хугацаанд 1 эхийн эндэгдэл / 2013 онд/ бүртгэгдэж, 2013 онд эндэгдлийн түвшин 66.3 (улсын дундаж 58.6) байсан ба 2014-2016 онуудад бүртгэгдээгүй байна.

Дорноговь аймгийн нийт хүн амын 27.1%-ийг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд эзэлж, жилд дунджаар 1481 эх эсэн мэнд амаржиж, 1491 хүүхэд эсэн мэнд бойжиж, жирэмсний эрт үеийн хяналтын хамралт 85.4%, жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээний түвшин 62.8%-д хүрчээ. Гэсэн ч 2011-2015 онд улсын хэмжээнд эндсэн эхчүүдийн 52,5% нь эх барихын шууд шалтгаанаар, 46,7% нь шууд бус шалтгаанаар, 32,9% нь ажилгүй, 25% нь малчин, 9,9% нь оюутан эхчүүд байснаас сургамж авч алдааг давтахгүй байхад анхаарах хэрэгтэй юм.

Манай аймгийн хэмжээнд жирэмсэн, төрөлттэй холбоотой ноцтой хүндрэлүүд бүртгэгдсээр байгаа, жирэмсний хожуу үедээ хяналтад орох тохиолдол дорвитой буурахгүй байгаа нь хотжилт, дэд бүтцийн хөгжил, уул уурхай, байнгын ажиллагаатай хилийн боомт, оюутан сурагчид, түр оршин суугч, шилжилт хөдөлгөөн, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна.

2016 оны байдлаар 1000 амьд төрөлтөнд ногдох перинаталь эндэгдэл 11.1 промилль, нялхсын эндэгдэл 14.6 (улсын дундаж 16.8), тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 16.7 (улсын дундаж 20.8) промилль, нялхсын эндэгдлийн 47,6 хувийг нярайн эндэгдэл, нярайн эндэгдлийн 80 хувийг нярайн эрт үеийн эндэгдэл тус тус эзэлж, 1 хүүхэд осол гэмтлийн улмаас нас барсан байна.

Хэдийгээр эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт улс аймгуудын дунджаас доогуур байгаа боловч эх хүүхдийн өвчлөл, жирэмсэн, төрөлттэй холбоотой эхийн ноцтой хүндрэл, эхийн эрхтэн тогтолцооны архаг өвчин, дутуу төрөлт, амьгүй төрөлт, төрөлт тойронгийн эмгэг, гажиг хөгжил буурахгүй байгаа нь нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 42,1% нь эрхтэн тогтолцооны ямар нэгэн эмгэгтэй, ялангуяа зүрх судас, шээс бэлэгсийн замын өвчин эмгэгтэй, гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс сэргийлэх,

жирэмсэн үеийн эрүүл ахуй, жирэмсний хүндрэл, эмнэлгийн тусламж эрт хайх мэдлэг хандлага, дадал хангалтгүй байгаа нь жирэмсэн, төрөх үеийн ноцтой хүндрэлд хүргэж байна.

2016 онд 0-5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл 8759 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс амьсгалын замын - 5552, хоол боловсруулах замын - 838, арьс харшлын - 712, нүдний дайвар харааны эмгэг - 517, чих хамар хоолойн - 487, осол гэмтлийн шалтгаант өвчлөл 338 тохиолдол бүртгэгдэж өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болж, цаашид нэмэгдэх хандлагатай байна.

2016 онд нялхас болон бага насны 14 хүүхэд /29 хоногоос 5 нас хүртэлх/ эндсэний 10 буюу 71.4 хувь нь харьцангуй сэргийлж, нас баруулахгүй байх боломжтой уушгины хатгалгаа өвчний хүндрэлээр эндсэн бөгөөд ахуйн осол, халуун хоол цайнд түлэгдэх явдал байсаар байна. Иймд бага насны хүүхдийг уушгины хатгалгаа болон амьсгалын замын өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвдсөн тохиолдолд эмчид хандаж, эмчилгээг бүрэн гүйцэд хийлгэх, өвчтэй хүүхдийг аян замд авч явахаас зайлсхийх, ахуйн ослоос сэргийлэх зэргээр эцэг эх, асран хамгаалагч нарт эрүүл мэндийн боловсрол, эмнэлгийн тусламж эрт хайх мэдлэгийг олгож анхаарал халамжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Бага насны хүүхдийн өвчлөл эндэгдлийг нэмэгдүүлэхэд нөлөөлж буй нэг хүчин зүйл нь 0-6 сартай хүүхдийн хөхөөр хооллолт өмнөх онтой харьцуулахад 3.1 хувиар буурч 76.5 хувьтай байгаа асуудал юм.

Товлолын дагуу хийх вакцинжуулалтад тус аймгийн бага насны хүүхдүүдийн 99.2 хувь нь хамрагддаг хэдий ч хүн амын шилжилт хөдөлгөөн, алслагдсан байдал, хүүхдийн өвчлөл, эмзэг байдлаас шалтгаалан давхардсан тоогоор жилдээ 70-80 орчим хүүхэд ямар нэг вакциныг товлолын дагуу хийлгэж чадахгүй хоцордог.

Аймгийн хүн амын 7.8%-ийг өсвөр насны хүүхдүүд эзэлдэг бөгөөд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, АШУҮИС-ийн салбар зэрэг сургуульд 20 хүртэлх насны 1277 өсвөр насны хүүхэд, залуучууд суралцаж байна. 2016 онд өсвөр насныхан, залуучуудын дунд 2014 онд 11079 байсан бол 2016 онд 15661 болж жилээс жилд нэмэгдэж, түүний 25.5% нь хоол боловсруулах, 17.8% нь бөөр, шээс ялгаруулах, 13.0% нь амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг, 12.5% нь хараа буурах, нүдний дайврын эмгэг, 9.9% нь арьс харшлын эмгэг байгаа ба 6 хүүхэд осол гэмтлийн шалтгаанаар нас барсан байна.

Сүүлийн жилүүдэд 20 хүртэлх насны охидын жирэмслэлт жилд дунджаар 169 бүртгэгдэж жилээс жилд нэмэгдэж, 2015 оны байдлаар улс аймгуудын дунджаас охидын жирэмслэлт 3.48, төрөлт 3.2, үр хөндөлт 3.1 –ээр өндөр байна. 2014 онд охидын жирэмслэлтийн түвшин 62,8, төрөлт 49,8, үр хөндөлт 13,8 байсан бол 2016 онд охидын жирэмслэлтийн түвшин 68,1, төрөлт 43,9, үр хөндөлт 24,1 болж, охидын жирэмслэлт, үр хөндөлт өсч, төрөлт буурсан байна. Тухайлбал 2014 онд 17 хүртэлх насны 15 охин үр хөндүүлсэн бол 2016 онд 19 болж өссөн нь охидын жирэмслэлт ихэсч үр хөндөлт хийлгэж байгаа нь анхаарал татаж байгаа юм.

2016 онд БЗДХ-ын 370 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд ногдох өвчлөл өмнөх оноос 1.4-өөр нэмэгдэж, нийт өвчлөлийн 38.1% нь заг хүйтэн, 37.5% нь тэмбүү, 24.3 % нь трихомониаз байгаа ба тэмбүү, заг хүйтний халдвар улс, аймгийн дунджаас 1-7.3-аар өндөр байна.

БЗДХ-аар өвчлөгчдийн 45.1%-ийг ажилгүй, 12.1%-ийг оюутнууд, 51%- нь 20-29 насны залуучууд, БЗДХ-ын кабинетаар үйлчлүүлэгсдийн 54.9%-ийг, бүртгэгдсэн өвчлөлийн 60.2%-ийг тус тус эмэгтэйчүүд эзэлдэг.

2016 онд жирэмсний хяналтад орсон эхчүүдийн 2.6%-д нь (улсын дундаж 1.9%) тэмбүү өвчин илэрсэн бөгөөд эрт илрүүлж, эрүүлжүүлснээр төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй ч өвчлөл өндөр байгаа нь төрөлхийн тэмбүү гарч болох эрсдэл байгааг анхааруулж байна.

Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч хөдөөгийн эмнэлгүүд жил бүр Гэр сувилал ажиллуулж бага насны хүүхдүүдийг байгалийн хүчин зүйлээр чийрэгжүүлж, хүүхдийн эмч нарын тоог нэмэгдүүлж, гадаад дотоодын сургалтад хамруулж, нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэлийг шат дараалалтай хийж, НҮБ-ын ХАС-ийн дэмжлэгтэйгээр 2014-2016 онд аймгийн болон Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгт “Өсвөр үе-Залуучуудад ээлтэй клиникийг нээж, 2016 онд хүүхдийн эмчийг сэтгэл зүйн зөвлөгөө өгөх сургагч багшаар бэлтгэн, эх барих эмэгтэйчүүдийн кабинет, хүүхдийн байгууллагуудын эмч нартай үйлчилгээг уялдуулан ажиллуулснаар тус төвд хандах хүүхдүүдийн тоо 2014 онд 1484 хүүхэд байсан бол 2016 онд 7610 болж жилээс жилд нэмэгдэж байна.

Жирэмсний хяналтын чанарыг сайжруулах зорилгоор 2007 оноос “Жирэмсний давхар хяналтын тогтолцоо”-г нэвтрүүлж, жирэмсэн эх бүрийг мэргэжлийн эмчийн хяналтад төрүүлэх зорилт тавьж, эх барих эмэгтэйчүүдийн эмч мэргэжилтнүүдийн орон тоог нэмэгдүүлж, анхан ба хоёрдох шатлалын эмнэлгүүдийн хамтын ажиллагааг сайжруулж, эмчилгээ оношилгоонд телемедициныг нэвтрүүлснээр тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч байна.

Гэсэн хэдий ч аймгийн хэмжээнд эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн өнөөгийн байдал нь иргэдийн эрэлт, хэрэгцээнд бүрэн нийцэхгүй байна. Иргэдийн гэр бүл төлөвлөлт, бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол дутмаг, гадны төсөл хөтөлбөрийг шугамаар жирэмслэхээс хамгаалах эм хэрэгслийн нийлүүлэлт буурч, иргэдийн худалдан авах чадвар дутмаг, эх барих эмэгтэйчүүд, нярай, хүүхэд, нойрсуулга, эрчимт эмчилгээний эмч, эх баригч нарын хангалт дутуу, тогтвор суурьшилтай ажиллахгүй, шилжилт хөдөлгөөн их, эмнэлгийн барилгын засвар үйлчилгээ, ээлтэй орчин, тоног төхөөрөмжийн хангалт дутмаг байгаа нь тусламжийн чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээ тухайлбал үргүйдэл, цэвэршилт, эрчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал анхаарал татаж эрэгтэйчүүдийн эмч мэргэжилтнүүдийг бэлтгэх, чадавхижуулах сургалтад шат дараалалтай хамруулах шаардлага байна.

Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдэх, нийгмийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, эхчүүд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Иймд эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн дэлхий нийтийн бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлоготой уялдуулан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Хөтөлбөрийн зорилго

Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, иргэдийн болон иргэний нийгмийн оролцоог хангах замаар эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд тэгш

хүргэснээр эх, хүүхдийн эндэгдлийг тогтвортой бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

Зорилт 1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг бусад салбарын бодлогод тусгах замаар эрх зүйн орчныг сайжруулж, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжсэнээр эх, хүүхдэд ээлтэй нийгэм, эдийн засгийн орчинг бүрдүүлнэ.

Зорилт 2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.

Зорилт 3. Нөхөн үржихүйн эрхийг хангасан гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх замаар хүсээгүй жирэмслэлт болон үр хөндөлтийг бууруулна.

Зорилт 4. Хүн амд жендэрийн мэдрэмжтэй эрүүл мэндийн боловсрол олгон эрүүл зан үйлийг төлөвшүүлэн эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахад гэр бүлийн гишүүд, иргэдийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.

Зорилт 5. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүртгэл, мэдээлэл, тандалт, судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээг сайжруулна.

2.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийг 2017-2021 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.1.1. Үйл ажиллагааны чиглэл 1. Бусад салбарын бодлогод эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг тусгах, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.1.1.1. Салбар хоорондын “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл”-ийг үйлчлүүлэгч, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор байгуулах;

3.1.1.2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдүүлэх, эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулахад бусад салбарын чиг үүргийг тодорхойлж, хамтран ажиллах;

3.1.1.3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэхэд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, хувийн хэвшил, иргэний нийгэм, олон нийтийн оролцоо, түншлэлийг нэмэгдүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах;

3.1.1.4. Олон эмэгтэй ажиллагчтай байгууллага, аж ахуйн нэгжид хүүхэд саатуулах, өдөр өнжүүлэх бүлэг ажиллуулах, хүүхэд хөхүүлэх өрөө гаргах зэргээр эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх;

3.1.1.5. Эрэгтэйчүүд олноор ажиллаж, суралцдаг салбарын ажилтан албан хаагч, цэрэг, сонсогчдод нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмол хийж, хамтран ажиллах;

3.1.1.6. Эх, хүүхдэд нэн шаардлагатай эрүүл хүнсний бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих үйл ажиллагааг өргөжүүлэх;

3.1.1.7. Хүүхэд, өсвөр үе, залууст нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх зан үйл төлөвшүүлэх албан болон албан бус боловсролын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

3.1.1.8. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлэх, эмчлэх, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

3.1.1.9. Төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, олон улсын байгууллагатай хамтран иргэдийн эсэн мэнд амьдрахуй болон амаржихуйн талаарх хандлага, дадлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх;

3.1.1.10. Эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлс (агаар, ус, хөрсний бохирдол, осол гэмтэл)-ийг бууруулах үйл ажиллагааг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулан хэрэгжилтийг хангуулах;

3.1.1.11. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг дэмжигч байгууллага, хамт олон, олон нийтийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах.

3.1.2. Үйл ажиллагааны чиглэл 2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.1.2.1. Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдэд үнэлгээ хийж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах;

3.1.2.2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний эрсдэлийн даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.1.2.3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

3.1.2.4. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, заавар, журмыг шинэчлэн боловсруулах.

3.1.3. Үйл ажиллагааны чиглэл 3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулахад санхүүгийн нөөцийг дайчлах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

3.1.3.1. Нөхөн үржихүйн насны нэг эмэгтэйд ногдох эрүүл мэндийн тусламжийн жилийн өртгийн тооцооллыг гаргаж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан шийдвэрлүүлэх;

3.1.3.2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндэд орон нутгийн төсвөөс зарцуулах санхүүжилтийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх;

3.1.3.3. Хүүхдэд хийж байгаа өндөр өртөгтэй оношилгоо, эмчилгээ, мэс заслын тусламж, үйлчилгээний зардлыг шинэчилсэн баримт бичиг, зааврыг мөрдүүлэх;

3.1.3.4. Орон нутагт эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих сан байгуулах үйл ажиллагааг өргөжүүлэх;

3.1.3.5. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэхэд шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрүүдийн уялдааг сайжруулж хэрэгжүүлэх;

3.1.3.6. “Эх, хүүхдэд ээлтэй эмнэлэг”, “Эх, хүүхдэд ээлтэй байгууллага”, “Эх, хүүхдэд ээлтэй орон нутаг” болох хөдөлгөөнийг өрнүүлэн эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулсан эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтнийг урамшуулах, сурталчилдаг болох.

Хүрэх үр дүн

Эх, хүүхдийн эрүүл мэндийн эрх зүйн орчин боловсронгуй болж, салбар хоорондын хамтын ажиллагаа, түншлэл сайжирч, санхүүгийн нөөц нэмэгдсэнээр эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдэнэ.

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.2.1. Үйл ажиллагааны чиглэл 1. Эх барих, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд оношилгоо, эмчилгээний дэвшилтэт аргыг нэвтрүүлж, бэлэн байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.2.1.1. Жирэмсэн эмэгтэйчүүдийн бүртгэл мэдээллийг сайжруулах, жирэмсний эрт хяналтын ач холбогдлыг тайлбарлан таниулахад иргэн, гэр бүл, хамт олон, нутгийн захиргааны байгууллагын оролцоог нэмэгдүүлэх замаар жирэмсэн эмэгтэйг жирэмсний эхний 3 сарын хугацаанд илрүүлж, хяналтад тогтмол хамруулах;

3.2.1.2. Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эх, 6-23 сартай хүүхдийг олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл, 5 хүртэлх насны хүүхдийг А, Д аминдэмээр бүрэн хангах;

3.2.1.3. Жирэмсний хяналт, төрөх үеийн тусламж үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг тэмбүү, ХДХВ, элэгний В, С вирусийн халдвар илрүүлэх оношлуур, лабораторийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангах боломж бүрдүүлэх;

3.2.1.4. Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт, магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтэд эх баригч ажиллуулах асуудлыг тусган хэрэгжүүлэх;

3.2.1.5. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны эмгэгийн эрт илрүүлэг, зөвлөгөө, хяналт, андрологи, үргүйдэл, цэвэршилтийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэг цэгийн үйлчилгээг аймгийн нэгдсэн эмнэлэгт байгуулан бэлгийн замаар дамжих халдварын тусламж, үйлчилгээг нөхөн үржихүй (эсэн мэнд амаржихуй) болон өсвөр үеийн тусламжтай нягт уялдуулсан байдлаар зохион байгуулах;

3.2.1.6. Аймгийн нэгдсэн эмнэлгийн 50 ортой амаржих газрын барилгыг ашиглалтад оруулах;

3.2.1.7. Халдварт өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг сайжруулах зорилгоор эмнэлгүүдэд ариутгал, халдваргүйтгэлийн чиглэлээр технологийн шинэчлэл хийх;

3.2.1.8. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлж байгаа (хөх, умайн хүзүүний хавдрын гэх мэт) эрт илрүүлэг, шинжилгээг үргэлжлүүлэх;

3.2.1.9. Эх барих, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинэ техник, технологийн шинэчлэлийг үе шаттайгаар нэвтрүүлэх;

3.2.1.10. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, тоног төхөөрөмжийн хангалт, засвар үйлчилгээний мэдээллийн сан байгуулж, инженер-техникийн үйлчилгээг орчин үеийн жишгийн дагуу хөгжүүлэх, энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх;

3.2.1.11. Малчид, отор нүүдэл хийж байгаа гэр бүлийн гишүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, бага насны хүүхдэд явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

3.2.1.12. Багийн эмчийг эх барих, нярай, хүүхдийн нэн шаардлагатай болон яаралтай тусламж үзүүлэх цомог, мэдээлэл, сурталчилгааны материалаар хангах;

3.2.1.13. Гамшиг, онцгой байдлын үед үзүүлэх эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардагдах хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, бичил тэжээл, тээврийн хэрэгсэл, шатахуун, санхүүгийн нөөцийг тогтоож, бэлэн байдлыг хангах;

3.2.1.14. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд удирдлагын болон мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт, үнэлгээ хийж, үр дүнг тооцож ажиллах.

3.2.2. Үйл ажиллагааны чиглэл 2. Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд оношилгоо, эмчилгээний дэвшилтэт аргыг нэвтрүүлэх, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.2.2.1. Аймгийн нэгдсэн эмнэлгээс хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах;

3.2.2.2. Нэгдсэн эмнэлэгт хүүхдийн мэс засал, мэдрэлийн болон нярайн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүрдүүлэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах;

3.2.2.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, амаржих газрын нярай, хүүхдийн тусламж, үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлж, оношилгоо, эмчилгээний багаж, хэрэгслээр хангах;

3.2.2.4. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хүүхдийн эмч ажиллуулах, архаг өвчтэй хүүхдийн хяналтыг аймгийн хүүхдийн мэргэжилтэн, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч нар хамтарч хийдэг болох;

3.2.2.5. Дутуу болон бага жинтэй төрсөн нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд оношилгоо, эмчилгээ, асаргааны шинэ технологи нэвтрүүлэх;

3.2.2.6. Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, тоног төхөөрөмжийн хангалт, засвар үйлчилгээний мэдээллийн сан байгуулж, инженер-техникийн үйлчилгээг орчин үеийн жишгийн дагуу хөгжүүлэх, энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх;

3.2.2.7. Эцэг, эх, асран хамгаалагчийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, гүйцэтгэлд суурилсан ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх замаар 1 хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлт, идэвхтэй хяналтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.2.2.8. Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинээр нэвтэрч байгаа (нярайн түнхний дисплази, дутуу нярайн ретинопати, бодисын солилцооны эмгэг, сонсголын эмгэг) эрт илрүүлгийг үргэлжлүүлэх;

3.2.2.9. Хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, чанарын удирдлага, бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгох;

3.2.2.10. Товлолын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн салбарын болон гэр бүл, хүүхэд, боловсролын байгууллагын хөтөлбөртэй уялдуулах;

3.2.2.11. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг нийлүүлэх.

3.2.3. Үйл ажиллагааны чиглэл 3. Өсвөр үе, залуучуудад үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- 3.2.3.1. Өсвөр үе, залуучуудад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шинэчлэгдсэн заавар, журмыг мөрдүүлэх;
- 3.2.3.2. Өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах;
- 3.2.3.3. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үе тэнгийн сургагч бэлтгэх сургалтыг өргөжүүлэх;
- 3.2.3.4. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн чанар, үр нөлөөг сайжруулах чиглэлээр орон нутгийн түвшинд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах;
- 3.2.3.5. Их сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн сургалтын хөтөлбөрт тусгасан нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- 3.2.3.6. Их сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн эмч нарыг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр сургалтад хамруулж, мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал, нөхөн үржихүйн нэн шаардлагатай эм, хэрэгслээр хангах;
- 3.2.3.7. Насан туршийн боловсролын төвийн сургалтын хөтөлбөрт нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг тусгаж, багш нарыг нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалтад хамруулах замаар сургууль завсардсан хүүхэд, ажилгүй залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг зохион байгуулах.

3.2.4. Үйл ажиллагааны чиглэл 4. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэхжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- 3.2.4.1. Газарзүйн болон хүн амзүйн мэдээллийг ашиглаж эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж ажиллуулах;
- 3.2.4.2. Эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, нярайн эмч, хүүхэд, өсвөр үеийн эмч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний ажлын байрны жишиг тодорхойлолтыг өнөөгийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах;
- 3.2.4.3. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах сургалтанд хамруулах, ур чадварын үнэлгээг боловсронгуй болгох;
- 3.2.4.4. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байранд болон эмнэлэг хооронд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, жирэмсэн эхчүүд, эх барих, нярай, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн яаралтай тусламжийн сургалтад тогтмол хамруулах;
- 3.2.4.5. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед гарч болзошгүй эрсдэл, ургийн хөгжлийн гажгийг эрт илрүүлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхыг нэмэгдүүлэх;
- 3.2.4.6. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эх, хүүхэд, нярай болон нөхөн үржихүй, цэвэршилтийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр багц цагийн, зайны болон олон улсын батламжтай сургалтад хамруулах, шинэлэг, зардал багатай, технологийн үр дүнтэй арга хэлбэр (mhealth, зайн анагаах ухаан)-ийг ашиглан чадавхжуулах үйл ажиллагааг өргөжүүлэх;
- 3.2.4.7. Эрэгтэйчүүдийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах;

3.2.4.8. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өвөрмөц хэрэгцээ шаардлагатай зорилтот бүлгийнхний (хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өсвөр үе, хүчирхийлэлд өртсөн иргэн) онцлогт тохирсон тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, чадавхжуулах;

3.2.4.9. Үндсэн мэргэжлийн эмч нарыг эх барих, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай болон яаралтай тусламжийн чиглэлээр сургалтад хамруулах мэдлэгийг нэмэгдүүлэх;

3.2.4.10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөц (хэл засалч, хөдөлгөөн засалч, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл зүйч)-ийг бэлтгэх.

Хүрэх үр дүн

Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт аргыг нэвтрүүлж, хүний нөөцийг чадавхжуулснаар эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар сайжирна.

3.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.3.1. Үйл ажиллагааны чиглэл 1. Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.3.1.1. Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний талаарх бодлого, шийдвэрийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргагч нарт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах;

3.3.1.2. Хот, суурин газарт шилжин суурьшигч болон оюутан залуучууд, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл хүргэх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

3.3.1.3. Ерөнхий мэргэжлийн эмч, эх баригч болон эрүүл мэндийн бусад холбогдох мэргэжилтнийг гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр давтан сургах, сургалтын хөтөлбөрт дээрх асуудлыг тусгах;

3.3.1.4. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээнд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагыг татан оролцуулах.

3.3.2. Үйл ажиллагааны чиглэл 2. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн тогтвортой хангамжийг бүрдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.3.2.1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл тухайлбал, бэлгэвч, дан болон хавсарсан дааврын эм, тариа, ерөндөг, суулгац, яаралтай ууж жирэмслэхээс сэргийлэх эм, бэлгийн замаар дамжих халдварыг илрүүлэх хурдавчилсан оношлуур, үтрээний наацын шинжилгээний хэрэгсэл, төмрийн бэлдмэл, фолийн хүчил зэргээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг хангах;

3.3.2.2. Жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийн санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлэх;

3.3.2.3. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг тодорхойлох, санхүүжилтийг тооцох, худалдан авах, хадгалах, чанарын баталгааг хангах, түгээх чадавхыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагад бүрдүүлэх;

3.3.2.4. Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн шугамаар ирсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хүлээн авах, хадгалах, түгээх үйл ажиллагааг эрчимжүүлэх.

3.3.3. Үйл ажиллагааны чиглэл 3. Үр хөндөлтийн өмнөх, дараах цогц тусламж, үйлчилгээг бэхжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.3.3.1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эмч нарыг үр хөндөлтийн өмнөх, дараах цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр давтан сургах;

3.3.3.2. Үр хөндөх ажилбар хийж байгаа эрүүл мэндийн байгууллагын үр хөндөлтийн тусламж, үйлчилгээг үнэлж, дүгнэлт гаргах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

3.3.3.3. Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээний стандартыг мөрдүүлэх дотоод хяналтыг сайжруулах ;

3.3.3.4. Хүсээгүй жирэмслэлт болон үр хөндөлтийн хор уршиг, гэр бүл төлөвлөлтийн ач холбогдлыг ойлгуулах мэдээлэл, сургалт, сурталчилгааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах;

3.3.3.5. Аюултай үр хөндөлтөөс сэргийлэх арга хэмжээг мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах.

Хүрэх үр дүн

Нөхөн үржихүйн эрхийг хангасан гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэглээ нэмэгдэж, хүсээгүй жирэмслэлт болон үр хөндөлт буурна.

3.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.4.1. Үйл ажиллагааны чиглэл 1. Зорилтот бүлгийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.4.1.1. Нийт хүн амд эх, хүүхэд, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, мэдлэг олгох ажлыг төрийн бус байгууллагатай хамтран олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүргэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

3.4.1.2. Зорилтот бүлэгт чиглэсэн гэр бүл төлөвлөлт, эсэн мэнд амаржихуй, эмийн зохистой хэрэглээ, хүүхдийн асаргаа сувилгаа, амны хөндийн эрүүл мэнд, хатгалгаа, суулгалт, үр хөндөлт, бэлгийн замаар дамжих халдвар, осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх асуудлаар зан үйлийг өөрчлөх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

3.4.1.3. Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хорт зуршил (архи тамхи, донтолт, стресс, бухимдал)-аас сэргийлэх, шийдвэр гаргах, татгалзах чадварт өсвөр үе, залуучуудыг сургах;

3.4.1.4. Гадаадад гэрээгээр ажиллахаар явж байгаа залууст бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал түгээх;

3.4.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийн талаар сургалт зохион байгуулах, баррель үсгээр сурталчилгааны материал боловсруулж түгээх;

3.4.1.6. Цэвэршилтийн насны хүн амд нөхөн үржихүйн дараах тусламж, үйлчилгээний талаар мэдээлэл, сурталчилгаа хийх, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг тэдний хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн зохион байгуулах;

3.4.1.7. Хүүхдийг эрүүл өсгөх, асрах, сувилах, өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчдад сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

3.4.1.8. Хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр аливаа эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, тусламж хайх, анхны тусламж үзүүлэх чиглэлээр иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах;

3.4.1.9. “100 хувь бэлгэвч” кампанит ажлыг хэрэгжүүлэх;

3.4.1.10. “Эх, хүүхдэд ээлтэй”, “Эрүүл мэндийг дэмжигч” байгууллага, аж ахуйн нэгж, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль шалгаруулах.

Хүрэх үр дүн

Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих асуудалд гэр бүлийн гишүүд, иргэний оролцоо, үүрэг хариуцлага нэмэгдэнэ.

3.5. Хөтөлбөрийн 5 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.5.1. Үйл ажиллагааны чиглэл 1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.5.1.1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн талаарх бүртгэл, мэдээллийг сайжруулах;

3.5.1.2. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийн хэрэглээг бүртгэх, тайлагнах үйл ажиллагааг эрүүл мэндийн анхан шатны тусламжийн түвшинд үнэлж боловсронгуй болгох;

3.5.1.3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн жагсаалт, бүртгэлийн маягтыг шинэчлэн боловсруулж батлуулах;

3.5.1.4. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг тооцох, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах аргачлалд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бүртгэл мэдээлэл болон мэдээлэл технологийн ажилтныг сургах;

3.5.1.5. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сан, зураглал бий болгох.

3.5.2. Үйл ажиллагааны чиглэл 2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тандалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.5.2.1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тандалтын тэргүүлэх чиглэлийг тогтоож, тандалтын заавар, маягтыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх;

3.5.2.2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр олон улсад өргөн хэрэглэгддэг тандалтын тогтолцоотой танилцах, сургалт зохион байгуулах;

3.5.2.3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн вебэд суурилсан тандалтыг нэвтрүүлж, мэдээллийг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах;

3.5.2.4. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээрх тандалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, өрсөлдөх боломжоор хангах.

3.5.3. Үйл ажиллагааны чиглэл 3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоон чадавхыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.5.3.1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих;

3.5.3.2. “Эх яагаад эндэв” үнэлгээг 3 жил тутам хийж, үнэлгээний дүнг шийдвэр гаргах, бодлого боловсруулах, үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд ашиглах;

3.5.3.3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр эмч, мэргэжилтний эрдэм шинжилгээ, судалгаа хийх чадавхийг дээшлүүлж, олон улсын нэр хүнд бүхий их сургууль, эмнэлгүүдтэй судалгааны чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

3.5.4. Үйл ажиллагааны чиглэл 4. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн бүртгэл мэдээлэл, судалгааны үр дүнгийн хэрэглээг сайжруулж, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл явцыг дэмжих нөхцөл бүрдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.5.4.1. Талбарын тархвар зүйн сургалтад орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын эх барих-эмэгтэйчүүд, хүүхдийн эмч, мэргэжилтэнг хамруулах;

3.5.4.2. Цаг агаар, газар зүйн байрлал, байгаль орчны нөлөөлөл, тухайн нөхцөлтэй уялдуулсан бүртгэл, тандалт, судалгааны мэдээллийг хэрэглэгч, шийдвэр гаргагч ашиглах боломжийг нэмэгдүүлэх;

3.5.4.3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үндэсний болон олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлийг захиалах, ашиглалтыг нэмэгдүүлэх;

3.5.4.4. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн жил бүрийн статистик болон тандалтын мэдээлэл, тухайн жил хийгдсэн судалгааны ажил, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны тайлан, бодлогын баримт бичгүүдийг нэгтгэсэн тойм (Annual Review)-ыг шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдад хүргэх.

Хүрэх үр дүн

Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээрх судалгаа, тандалт, статистик бүртгэл, мэдээлэл чанаржиж, нотолгоонд суурилсан бодлого шийдвэр гарах боломж бүрдэнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө:

4.1.1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн бодлого, эрх зүйн орчин, салбар дундын болон салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдаа сайжирч, үйл ажиллагааны давхцал, орхигдол буурна.

4.1.2. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн худалдан авалт, нийлүүлэлт үр ашигтайгаар зохион байгуулагдаж, гэр бүл төлөвлөлтийн хангагдсан хэрэгцээ нэмэгдэж, хүсээгүй жирэмслэлт болон үр хөндөлт буурна.

4.1.3. Хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг эрчимтэй явуулснаар хүүхдийн сэргийлж болох өвчлөл, эндэгдэл багасна.

4.1.4. Эх, эмэгтэйчүүд, хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучууд болон эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах орчин, хүртээмж, чанар сайжирна.

4.1.5. Ургийн болон нярайн төрөлхийн хөгжлийн гажгийг эрт илрүүлэн хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлнэ.

4.1.6. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, иргэний оролцоо нэмэгдэж, эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдэнэ.

4.2. Хөтөлбөрийн эдийн засгийн үр нөлөө:

4.2.1. Эх, хүүхдийн эндэгдлээс урьдчилан сэргийлэх хамгийн үр ашигтай, нотолгоонд суурилсан арга болох нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэснээр хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлнэ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцооллоор гэр бүлээ зөв төлөвлөж, хүсээгүй жирэмслэхээс сэргийлж чадвал эхийн эндэгдлийн 25-40 хувийг сэргийлэх боломжтой бөгөөд энэ нь эдийн засгийн асар их өгөөжтэйг тогтоосон байна.

4.2.2. Дэлхийн хэмжээнд жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэлд зарцуулсан 1 ам.доллар тутамд жирэмсэн үеийн тухайлбал, эрсдэлтэй жирэмсэн үеийн тусламж, үйлчилгээтэй холбоотой зардлыг 1.47 ам.доллараар бууруулах боломжтой гэж үздэг.

4.2.3. Гэр бүл төлөвлөлт нь эрүүл мэндийн зардлыг бууруулахаас гадна эмэгтэйчүүдийн эрхийг дэмжиж, тэдний боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх замаар гэр бүлийн сайн сайхан байдлыг дэмждэг.

4.2.4. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэн пренатал оношилгоо эмчилгээ, үргүйдэл, хүүхдийн зүрхний гажгийн тусламжийг эх орондоо үзүүлснээр гадаад руу урсах зардал багасч, иргэнд учрах эдийн засгийн дарамт буурна.

4.2.5. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулснаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл буурч, эхийн эндэгдлээс сэргийлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал буурна.

4.2.6. Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад бүх нийтийн оролцоог хангаснаар хүүхдийг өвчнөөс урьдчилан сэргийлэх хүн амын мэдлэг, хандлага дээшилж, эрүүл зан үйл төлөвшиж, эмнэлэгт хэвтэлт багассанаар эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодит зардал буурна.

4.2.7. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг үзүүлснээр бага өртгөөр олон нярайн амь насыг аварна.

4.2.8. Хөх, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэлтийг сайжруулснаар халдварт бус өвчний шалтгаант нас баралтыг бууруулна.

4.2.9. Эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг өргөжүүлснээр эмнэлгийн ор хоногийн зардал багасч, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

4.2.10. Хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр салбар дундын хамтын ажиллагаа сайжирснаар сэргийлж болох өвчлөл, эндэгдлийг бууруулна.

4.3. Хөтөлбөрийн 5 зорилтын хүрээнд 14 чиглэлээр 102 үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.

4.4. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

4.4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үр нөлөөний болон үр дүнгийн дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2016 оны эрүүл мэндийн үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглана:

	Хөтөлбөрийн зорилго, зорилт	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	
			Суурь үзүүлэлт 2016	2020
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт				
Зорилго	Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлж хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, иргэдийн болон иргэний нийгмийн оролцоог хангах замаар эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд тэгш хүргэснээр эх, хүүхдийн эндэгд-лийг тогтвортой бууруулна.	Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд)	0	0
		5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	16.7	Суурь түвшингээс доогуур
		Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	14.6	Суурь түвшингээс доогуур
		Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	6.9	Суурь түвшингээс доогуур
		Перинатал эндэгдлийн түвшин (1000 нийт төрөлтөд)	11.2	Суурь түвшингээс доогуур
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт				
Зорилт 2	Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.	Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	85.4	88.4
		Жирэмсний хугацаанд 6 болон түүнээс дээш үзүүлсэн эхийн эзлэх хувь	68.6	95.0
		Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын түвшин (100,000 амьд төрөлтөд)	0	0
		Жирэмсний 18-21 долоо хоногийн хугацаанд ургийг (бүтцийн) хэт авиан шинжилгээнд хамруулсан хувь	97.5	100
		Төрөлт бүрт нэг удаагийн цомог хэрэглэсэн хувь	40	100
		Кесарево хагалгааны дараах ноцтой хүндрэлийн хувь	1.8	1.3
		Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хэрэгжилтийн хувь	81.1	100

Зорилт 3	Нөхөн үржихүйн эрхийг хангасан гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх замаар хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийг бууруулна.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувь	51.5	63
		Үр хөндөлтийн түвшин (1000 амьд төрөлтөд)	416.4	200
		Жирэмслэхээс сэргийлэх 5-аас доошгүй эм, хэрэгслээр үйлчилж байгаа анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хувь	78.9	90
Зорилт 4	Хүн амд жендэрийн мэдрэмжтэй эрүүл мэндийн боловсрол олгон эрүүл зан үйлийг төлөвшүүлж, эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад гэр бүлийн гишүүд, иргэдийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.	ХДХВ/ДОХ-ын талаар цогц мэдлэгтэй 15-24 насны залуучуудын хувь Эмэгтэй Эрэгтэй	-	50
		15-19 насны охидын төрөлтийн түвшин(15-19 насны 1000 охидод)	44	30
		Осол гэмтлээс шалтгаалсан хүүхдийн эндэгдлийн тохиолдол	6	Суурь түвшингээс доогуур
		5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд уушгины хатгалгаа өвчний шалтгаант нас баралтын эзлэх хувь	25	Суурь түвшингээс доогуур
		6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллосон хүүхдийн эзлэх хувь	76.5	Суурь түвшингээс нэмэгдүүлэх
Зорилт 5	Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүртгэл, мэдээлэл, тандалт, судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээг сайжруулна.	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг батлагдсан маягтын дагуу цахим хэлбэрээр мэдээлж байгаа эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь	0	100
		Тав хүртэлх насны хүүхдийн төрөлхийн хөгжлийн гажгийг батлагдсан маягтын дагуу цахим хэлбэрээр мэдээлж байгаа эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь	0	100
		Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн тандалтыг хэрэгжүүлж байгаа эмнэлгийн хувь	0	100

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт, хугацаа

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. улсын төсөв;

5.1.2. эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгө;

5.1.3. олон улсын байгууллага, гадаад улс орны төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, хөнгөлөлттэй зээл, тусламж;

5.1.4. төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

5.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр. / орон нутаг/

5.2. Хөтөлбөрийг 2017-2021 онд хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг олон улсын байгууллага, гадаад орны төсөл, хөтөлбөрийн хөрөнгө орон нутгийн дэмжлэгээр хэрэгжүүлнэ гэсэн урьдчилсан тооцоололтой байна.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын болон гүйцэтгэлийн дотоод хяналт-шинжилгээг эрүүл мэндийн газар, хөндлөнгийн хяналт-шинжилгээг аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн яам, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөл гүйцэтгэнэ.

6.2. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд нь хөтөлбөрийн хэрэгжилтийн хагас бүтэн жилийн тайланг аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг Эрүүл мэндийн газар гүйцэтгэж, тайланг аймгийн Засаг дарга Эрүүл мэндийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн, Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.

6.4 Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6.5. Үр дүнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмж нь холбогдох бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл болно.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

7.1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн салбар зөвлөл салбар дундын хамтын ажиллагаа оролцоог идэвхижүүлж, дэмжлэгт удирдлагаар хангах, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

7.2. Орон нутгийн хэмжээнд дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, удирдлага зохицуулалт хийх, хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг Эрүүл мэндийн газар гүйцэтгэнэ.